



АРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 30 өдөр

Дугаар А/42

Эрдэнэбулган сум

Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх,
Дотоод аудитын хороог шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10 дахь заалт, мөн хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэг, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 4.12, 4.13, 4.14 дэх хэсэг, Сангийн сайдын 2019 оны 29 дүгээр тушаалаар батлагдсан “Дотоод аудитын хорооны дүрэм”-ийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх Дотоод аудитын хорооны бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Хорооны нарийн бичгийн даргаар Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны Ахлах дотоод аудитор (А.Буяндэлгэр)-ийг томилсугай.

3.Дотоод аудитын хорооны дүрмийг үйл ажиллагаандаа мөрдөхийг аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба, Дотоод аудитын хорооны гишүүдэд, дүрмийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Алтангэрэл)-д тус тус үүрэг болгосугай.

4.Энэ захирамж гарсантай холбогдуулан Архангай аймгийн Засаг даргын 2022 оны 03 сарын 30-ний өдрийн А/210 тоот захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Б. ЦЭРЭННАДМИД

65241 1.5

Аймгийн Засаг даргын 2011 оны
01 сарын 30 ны өдрийн 44 дугаар
захирамжийн хавсралт



д/д	Овог нэр	Гүйцэтгэх үүрэг	Албан тушаал
1	Б.Цэрэннадмид	Хорооны дарга	Архангай аймгийн Засаг дарга
2	Д.Гандолгор	Хорооны гишүүн	Дотоод аудитын нэгжийн дарга
3	Ж.Мөнхбат	Хорооны гишүүн	Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
4	Б.Адъяа	Хорооны гишүүн	Статистикийн хэлтсийн дарга
5	Д.Хүрэлсүх	Хорооны гишүүн	Аймгийн ИТХ-ын төлөөлөгч
6	Ц.Батцэцэг	Хорооны гишүүн	Мэргэшсэн нягтлан бодогчдын төлөөлөл
7	В.Удвал	Хорооны гишүүн	Архангай дахь Өмгөөлөгчдийн зөвлөлийн өмгөөлөгч